



АГУУЛГА

Аудитыг гүйцэтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
	Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3
	Товч танилцуулга	4
Гүйцэтгэлийн аудитын газар	Бүлэг 1. Аудитын зөвлөмжийг хангалттай хэрэгжүүлсэн бөгөөд хууль шинэчлэгдсэнээр зарим зохицуулалтыг цаашид мөрдөх шаардлагагүй болжээ	6
Газрын захирал, тэргүүлэх аудитор	Улсын Их Хурлаас 2017 онд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчлэн баталснаар Зөвлөмж 1-ийг хэрэгжүүлэх шаардлагагүй болсон байна	6
М.Давааням		
Аудитын менежер	Аудитын зөвлөмж 2-ын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хавсралтаар баталж ирсэн боловч хуульд өөрчлөлт орсноор уг зохицуулалтыг хийх шаардлагагүй болсон байна	6
З.Ариунзаяа		
Ахлах аудитор:		
Б.Болормаа		
Аудитор	Монгол Улсын Хөгжлийн банк арилжааны банкинд байршуулсан Чингис бондын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн ажлуудыг хийсэн байна	7
Г.Бямбаа		
2017 оны 6 дугаар сар	Монгол Улсын Хөгжлийн банк судалгаа, шинжилгээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг болсон байна	8
Аудитын дүн, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах, холбогдох саналаа өгөхийг хүсвэл 261456 дугаарын утсаар харилцана уу.	Зөвлөмж 5-ын дагуу Монгол Улсын Хөгжлийн банк төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулан ажилласан байна	9
Аудитын тайланг YAAG-ын www.audit.mn цахим хуудаснаас үзнэ үү.	Бүлэг 2. Монгол Улсын Хөгжлийн банк аудитаар илрүүлсэн зөрчлийг бүрэн арилгасан байна	10
ХАЯГ:	Албан шаардлагын хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн ажлууд хийгдсэн байна	10
Үндэсний аудитын газар		
Засгийн газрын IV байр	"Зээл төлүүлэх тухай" 2014 оны 01/77 YAAG-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагыг биелүүлж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгасан байна	10
Бага тойруу-3,		
Чингэлтэй дүүрэг,		
Улаанбаатар хот 15160	"Сангийн сайдын тушаалыг зөрчиж томилолтын зардал олгосон тухай" 2014 оны 01/78 YAAG-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг бүрэн арилгасан байна	10
	"Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг зөрчсөн тухай" 2014 оны 01/80 YAAG-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг бүрэн арилгажээ	10
	"Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай" 2014 оны 01/82 YAAG-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг арилгасан байна	11
	Дүгнэлт	12
	Холбогдох байгууллагын санал	13
	Саналд өгсөн тайлбар	13
	Монгол Улсын Ерөнхий Аудиторын тушаал	14

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
МҮХАҮТ	Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭЗХЯ	Эдийн засгийн хөгжлийн яам

Аудит хийсэн үндэслэл

Аудитын зорилт

Аудитын хамарсан хүрээ

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитад ашигласан шалгуур

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2017 оны А/12 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Үндэсний аудитын газраас 2015 онд хийсэн “Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд давтан аудит хийж, үр дүнг олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн.

Аудитад Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яам болон бусад холбогдох байгууллагуудыг хамруулав.

Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Монгол Улсын Хөгжлийн банк, Сангийн яамны холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа, тодруулга авах зэрэг аудитын арга зүйг ашиглан цуглуулсан нотлох баримтад судалгаа, харьцуулалт, дүн шинжилгээ хийж нэгтгэн аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газарт өгөв.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох тайлан, мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Өрийн удирдлагын тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль;
- Компанийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100;
- Гүйцэтгэлийн аудитын журам;
- Бусад холбогдох хууль, эрхийн актууд ашиглагдсан.

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Засгийн газрын 2010 оны 195 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Хөгжлийн банк (цаашид “МУХБ” гэх) байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Засгийн газрын 2011 оны 151 дүгээр тогтоолоор МУХБ-ны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг баталж, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн дагуу албан ёсоор 2011 оны 3 дугаар сарын 25-ны өдөр тус банк үүсгэн байгуулагдаж, үйл ажиллагаа нь эхэлжээ.

Үндэсний аудитын газраас 2014-2015 онд “Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудит хийж, аудитын дүнд үндэслэн Засгийн газар болон тус банкны гүйцэтгэх удирдлагад хандсан зөвлөмж, албан шаардлага өгсөн.

Дээрх аудитаар Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг сонгох, улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүнд тусгуулж байх зэрэг чиглэлээр дараах зөвлөмжийг өгсөн. Үүнд:

Хүснэгт № 1 Аудитаар өгсөн зөвлөмжийн жагсаалт

	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжилтийн байдал
Зөвлөмж 1	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ-ын жил бүрийн хаврын чуулганаар батлуулж байх;	Бүрэн хэрэгжүүлсэн
Зөвлөмж 2	Чингис бондын хөрөнгөөр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд зээлийн хүү төлөхийг зогсоох, улмаар уг эх үүсвэр болон төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүнд оруулан төлөвлөж, санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх;	Бүрэн хэрэгжүүлсэн
Зөвлөмж 3	Чингис бондын хөрөнгийн арилжааны банкинд байршсан чөлөөт үлдэгдлийг эрсдлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Бүрэн хэрэгжүүлсэн
Зөвлөмж 4	Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг сонгохдоо Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 28/20 дугаар зөвлөмжийн 2.2 дугаар заалт, Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах;	Бүрэн хэрэгжүүлсэн
Зөвлөмж 5	Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	Бүрэн хэрэгжүүлсэн

МУХБны бүтэц болон Төлөөлөн удирдах зөвлөлийн (цаашид “ТУЗ” гэх) үйл ажиллагаа, хараат бус гишүүнийг томилох асуудлыг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулинд заасан шаардлагад нийцүүлэн ажиллах зэрэг чиглэлээр дараах албан шаардлагыг өгсөн. Үүнд:

Хүснэгт №2 Албан шаардлагын жагсаалт

№	Албан шаардлагын огноо, дугаар	Албан шаардлагын утга	Хэрэгжилтийн байдал
1	2014 оны 01/77 УАГ- ГАГ/2014/ГА-6	Зээл төлүүлэх тухай	Бүрэн хэрэгжүүлсэн
2	2014 оны 01/78 УАГ- ГАГ/2014/ГА-6	Сангийн сайдын тушаалыг зөрчиж томилолтын зардал олгосон тухай	Бүрэн хэрэгжүүлсэн
3	2014 оны 01/80 УАГ- ГАГ/2014/ГА-6	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг зөрчсөн тухай	Бүрэн хэрэгжүүлсэн
4	2014 оны 01/82 УАГ- ГАГ/2014/ГА-6	Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний тухай	Бүрэн хэрэгжүүлсэн

Зөвлөмж, албан шаардлагын талаарх мэдээллийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон МУХБ-наас Үндэсний аудитын газарт ирүүлсэн бөгөөд аудитаар дээрх мэдээллийн мөрөөр давтан шалгалт хийсэн болно.

Бүлэг 1

Аудитын зөвлөмжийг хангалттай хэрэгжүүлсэн бөгөөд хууль шинэчлэгдсэнээр зарим зохицуулалтыг цаашид мөрдөх шаардлагагүй болжээ

Улсын Их Хурлаас 2017 онд Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг шинэчилэн баталснаар Зөвлөмж 1-ийг хэрэгжүүлэх шаардлагагүй болсон байна

Зөвлөмж 1. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг УИХ-ын жил бүрийн хаврын чуулганаар батлуулж байх.

1.1. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2015 оноос эхлэн Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу МУХБ-ны эх үүсвэрээр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүн хэсэг буюу Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хууль, 2017 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар тус тус батлуулсан байна. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт № 3 Монгол Улсын 2015-2016 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөл, арга хэмжээнүүд

(тэрбум төгрөгөөр)								
Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуулиар			Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хуулиар			Нийт дүн		
ТАХ-ний тоо	төсөвт өртөг	санхүүжих дүн	ТАХ-ний тоо	төсөвт өртөг	санхүүжих дүн	ТАХ-ний тоо	төсөвт өртөг	санхүүжих дүн
214	2,112.9	452.4	109	1,336.7	311.6	323	3,449.6	764.0

1.2. Дээрх хуулиар 2015-2016 онд нийт 3,449.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 323 төсөл арга хэмжээнд 764.0 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор батлагдсан байна.

1.3. УИХ-аас 2017 оны 2 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-т заасны дагуу МУХБ-наас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрүүд нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байхаар зохицуулсан учир МУХБ-ны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг цаашид УИХ-аар тусгайлан батлуулж байх шаардлагагүй болсон байна.

Аудитын зөвлөмж 2-ын дагуу Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх төсөл, хөтөлбөрийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хавсралтаар баталж ирсэн боловч хуульд өөрчлөлт орсноор уг зохицуулалтыг хийх шаардлагагүй болсон байна

Зөвлөмж 2. Чингис бондын хөрөнгөөр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд зээлийн хүү төлөхийг зогсоох, улмаар уг эх үүсвэр болон төсөл, арга хэмжээг улсын төсвийн хөрөнгө оруулалтын бүрэлдэхүүнд оруулан төлөвлөж, санхүүжүүлэх асуудлыг судалж шийдвэрлэх.

1.4. 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс өмнө мөрдөгдөж байсан МУХБ-ны “Зээлийн бодлого”-ын 5 дугаар зүйлийн 5.1-д “Банкны зээлийн хүү нь эх үүсвэрийн өртөг болон үйл ажиллагааны зардал, эрсдэлийн хураамжийн нийлбэртэй тэнцүү байх ба хүүг тухай бүрт Зээлийн хороо тогтооно. Банкны эх үүсвэрийн өртөг болон үйл ажиллагааны зардлыг тооцсон хүүг суурь өртөг гэх бөгөөд Хөгжлийн банкнаас олгох зээлийн хүүгийн доод хязгаар болно” гэж заасан байна.

1.5. Дээрх “Зээлийн бодлого”-ын дагуу МУХБ нь улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийг олгохдоо үйл ажиллагааны зардлыг нөхөх 1 хувиар нэмэгдүүлэн тооцсон зээлийн хүүг баримталж иржээ.

1.6. УИХ-ын 2016 оны “Монгол Улсын Хөгжлийн банкны талаар авах арга хэмжээний тухай” 81 дүгээр тогтоол, Засгийн газрын 2016 оны “УИХ-ын тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” 219 дүгээр тогтоолоор Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Хөгжлийн банк хооронд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй үүссэн өр, авлагыг 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон харилцан суутгах замаар эцэслэн шийдвэрлэх тухай шийдвэр гарсан байна.

1.7. Ийнхүү Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль 2017 оны 2 дугаар сард шинэчлэн батлагдсантай холбогдуулан Хөгжлийн банк нь Чингис бондын хөрөнгөөр улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд зээлийн хүү төлөх болон улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас зээл олгохыг зогсоосон буюу зөвлөмжийг биелүүлсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн банк арилжааны банкинд байршуулсан Чингис бондын хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг эрсдэлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн ажлуудыг хийсэн байна

Зөвлөмж 3. Чингис бондын хөрөнгийн арилжааны банкинд байршсан чөлөөт үлдэгдлийг эрсдэлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

1.8. Чингис бондын хөрөнгийн үлдэгдлийг эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2015 оны А-16 дугаар тушаалаар “Монгол Улсын Хөгжлийн банкнаас арилжааны банкуудад хадгаламж байршуулах, татан төвлөрүүлэх журам”-ыг баталсан байна.

1.9. Арилжааны банкинд байршуулсан Чингис бондын хөрөнгийн үлдэгдлийг эрсдэлээс хамгаалах, төсөл хөтөлбөрийн санхүүжилтэд татан авахад бэлэн байдлыг хангах, эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулахад чиглэсэн дараах ажлуудыг хийжээ. Тухайлбал,

- 1.9.1 Чингис бондын хөрөнгийн үлдэгдлийг санхүүгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангасан байдал, тухайн банкны сар бүрийн санхүүгийн тайланг үндэслэн дотоодын арилжааны банкуудад байршуулсан хөрөнгөд эрсдлийн үнэлгээ хийж, байршуулж болох мөнгөн хадгаламжийн дээд хязгаарыг тогтоож, мөнгөн хадгаламж тус бүрийн хугацааны эцэст хийгдэх үндсэн болон хүүгийн төлбөрийг энгийн вексель бичүүлэх замаар давхар баталгаажуулж байна;

- 1.9.2. Мөнгөн хадгаламжийг арилжааны банкинд байршуулахдаа банк тус бүртэй гэрээ байгуулж, хадгаламжийг дуусах хугацаанаас нь өмнө буцаан дуудах эрхтэй ба тухайн үед байршсан хугацаанд ногдох хүүг гэрээний үндсэн хүүгийн түвшингээр тооцдог болсон байна;
- 1.9.3. МУХБ-ны ашигт ажиллагааг хангах үүднээс олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн богино болон урт хугацаат эх үүсвэрүүдийн үлдэгдлийг Засгийн газрын үнэт цаас, банк хоорондын мөнгөн хадгаламж зэрэг хүүгийн орло олдог активт байршуулж байна;
- 1.9.4. Чингис бондын хөрөнгийг Засгийн газрын тогтоолоор төсөл, хөтөлбөрт хуваарилан, зарцуулагдаагүй үлдэгдлийг хүүгийн орлого олох активт мөнгөн хадгаламж хэлбэрээр байршуулж иржээ. Уг эх үүсвэрийг Сангийн яаманд шилжүүлсэн тул МУХБ-д Чингис бондын хөрөнгийн үлдэгдэл одоогоор байхгүй байна.

1.10. Дээрх ажлын үр дүнд МУХБ-наас арилжааны банкинд байршуулсан Чингис бондын хөрөнгийг эрсдэлээс хамгаалах, Чингис бондын эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах, хөрөнгийн үлдэгдлийг төсөл, хөтөлбөрийн санхүүжилтэд шуурхай татан авахад бэлэн байдал хангагдаж, хүүгийн алдагдал хүлээхгүй нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Монгол Улсын Хөгжлийн банк судалгаа, шинжилгээ, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, төсөв хийгдсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлдэг болсон байна

Зөвлөмж 4. МУХБ-ны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг сонгохдоо Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.2 дугаар заалт, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах.

1.11. Аудитаар МУХБ-ны хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээг сонгохдоо Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлийн 2012 оны 28/20 дугаар зөвлөмжийн 2.2 дахь заалт¹, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10 дугаар зүйлд² заасан шаардлагыг бүрэн хангаж ажиллах талаар зөвлөмж өгсөн.

1.12. МУХБ нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 3 дугаар зүйлийн 3.6-д³ заасныг үндэслэн Засгийн газрын тогтоолд нэр заасан компаниудтай шууд гэрээ байгуулж, санхүүжүүлж байсан байна.

1.13. Засгийн газрын тогтоолд төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагыг шууд заасантай холбогдон МУХБ-ны үйл ажиллагааг хууль, журмын дагуу явуулахад зарим хүндрэл гарч, холбогдох зээлийн судалгааг хийж эрсдэл, үр ашгийг тодорхойлох, хөгжлийг дэмжих үр ашигтай, эргэн төлөгдөх баталгаа бүхий төсөл, хөтөлбөрийн хэрэгжүүлэгчийг сонгон санхүүжүүлэх боломж хязгаарлагдаж байсан байна.

¹ “ЗГ-ын хүлээх эрсдэлийг багасгах, хөрөнгө оруулалтын орчныг дэмжих үүднээс нэг төсөл, хөтөлбөрт хийх санхүүжилт тухай төслийн санхүүжилтийн 1/3-аас хэтрэхгүй байх, МУ-ын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжинд санхүүжүүлэх”

² 10.1. Хөгжлийн банкнаас сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн санхүүжүүлэх төсөл, хөтөлбөр нь дараахь шаардлагыг хангасан байна:

10.1.1. Засгийн газрын баталсан Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарт хамаарах;

10.1.2. төсөл, хөтөлбөрийн зураг төсөл, төсөв, техник, эдийн засгийн үнэлгээ хийгдсэн байх;

10.1.3. эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, эсхүл олон улсын болон Европын холбооны стандартын шаардлагад нийцсэн экспортын болон импортын орлох нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд чиглэсэн байх;

10.1.4. зээлийн эрсдэлийн үнэлгээ, зээл авах үндэслэл, төсөл, хөтөлбөрийн эдийн засаг, нийгмийн үр өгөөжийг олон улсад тогтсон мэргэжлийн шинжилгээ, үнэлгээний аргачлал, шалгуурын дагуу тооцсон байх;

10.1.5. төсөл, хөтөлбөрийн үр дүнд бий болсон хөрөнгийг тухайн зээл бүрэн төлөгдөж дуусах хүртэл зээлийн барьцаа хөрөнгөд тооцсон байх.

³ 10.1. “Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбогдсон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй”

1.14. УИХ-аас 2017 онд шинэчилэн баталсан МУХБ-ны тухай хуулинд Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөгжлийн бодлогод нийцсэн байх, эдийн засгийн болон санхүүгийн үр ашигтай, зээлийг эргэн төлөх чадвартай байх зэрэг шаардлагыг хангасан төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэхээр заасны дагуу Хөгжлийн банк өөрийн судалгаа, шинжилгээнд үндэслэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр болсон байна.

Зөвлөмж 5-ын дагуу Монгол Улсын Хөгжлийн банк төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулан ажилласан байна

Зөвлөмж 5. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

1.15. МУХБ нь аудитаар төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх тухай зөвлөмжийн дагуу зээлдэгчийн санхүүгийн тайланд дүн шинжилгээ хийж, мөнгөн урсгал, эрсдэлийн түвшинг тухай бүр үнэлэн, зээлийг барьцаа, баталгаагаар хангуулан, холбогдох дүрэм, журмын дагуу олгосон зээлүүдэд хяналт тавин ажиллаж байна.

1.16. МУХБ-наас Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн 1.10-т “Хөгжлийн банкны бонд, зээлийн зарцуулалтыг дүгнэж, төсөл, хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалтын бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлнэ” гэж заасны дагуу төсөл хөтөлбөрүүдэд үнэлгээ хийж, эрсдэлийг тооцоолох, хугацаа хэтэрсэн зээлийг төлүүлэх арга хэмжээг холбогдох гэрээнд заасны дагуу “Бизнес төлөвлөгөө”-дөө тусган хэрэгжүүлж байна. Тухайлбал,

- МУХБ-ны шинэчилсэн бүтцийн хүрээд хяналт шалгалт, хянан нийцүүлэх чиглэлээр ажиллах нэгжийг байгуулж, улирал тутам төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлсэн;
- Банкны бизнес төлөвлөгөөнд зээлийн хяналтын төлөвлөгөөг боловсруулж, хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн багцад хяналт тавьж, зөрчил үүссэн зээлдэгчидтэй хамтран ажиллах замаар эргэн төлөлтийг хангуулах, зээлд бүтцийн өөрчлөлт оруулах, түүний гүйцэтгэлд хяналт тавьдаг болсон;
- МУХБ-ны бонд, зээлийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрт үнэлгээ хийж, зориулалт бусаар ашигласан, хугацаа хэтэрсэн зээлийг буцаан төлүүлэх зэрэг зорилтыг тусгаж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.17. Төсөл хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад тавих хяналтыг сайжруулах, үр дүнг нарийвчлан тооцох, төсөл хэрэгжүүлэгчдээс эргэн төлөгдөх зээлийн найдвартай баталгаатай байдлыг хангуулах чиглэлээр тодорхой ажлыг санаачлан хэрэгжүүлж иржээ.

Бүлэг 2

**Монгол Улсын Хөгжлийн банк аудитаар илрүүлсэн зөрчлийг
бүрэн арилгасан байна**

Албан шаардлагын хэрэгжилтийг хангуулахад чиглэсэн ажлууд хийгдсэн байна

2.1. Үндэсний аудитын газраас МУХБ-ны удирдлагад тус банкны бүтэц, Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, хараат бус гишүүнийг томилох болон бусад асуудлыг холбогдох хуулинд заасан шаардлагад нийцүүлэх талаар дөрвөн албан шаардлага өгсөн.

“Зээл төлүүлэх тухай” 2014 оны 01/77 УАГ-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагыг биелүүлж, аудитаар илэрсэн зөрчлийг арилгасан байна

2.2. Засгийн газрын 2014 оны 152 дугаар тогтоолоор “Төрийн өмчийн хороо, Лондонгийн хөрөнгийн бирж болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн хооронд байгуулсан “Хамтран ажиллах мастер гэрээ”-ний дагуу төлөх төлбөрийг санхүүжүүлэх зорилгоор Сангийн яам, Хөгжлийн банк болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ны хооронд 2014 оны 71/3-БС-ХО 2014-68/07 дугаартай “Гурван талт зээлийн гэрээ”-г байгуулсан байна. Гэрээний дагуу 2014 оны 5 дугаар сарын 26-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д жилийн 7 хувийн хүүтэй 1.4 сая ам.доллар буюу 2,726.9 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

2.3. Зээл, зээлийн хүүгийн төлбөр 1.4 сая ам.доллар болон нэмж хуримтлуулсан хүүгийн төлбөр 0.2 сая ам.доллар, нийт 1.6 сая ам.доллар буюу 3,320.6 сая төгрөгийг Сангийн яамнаас 2016 онд бүрэн төлсөн байна.

“Сангийн сайдын тушаалыг зөрчиж томилолтын зардал олгосон тухай” 2014 оны 01/78 УАГ-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг бүрэн арилгасан байна

2.4. МУХБ-ны Гүйцэтгэх захирлын 2013 оны А-127 дугаар тушаалаар баталсан “Албан томилолтын журам”-д “МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн албан тушаалтнууд, гүйцэтгэх удирдлага, мэргэжилтэн, албан хаагчдын орон нутаг болон гадаад улсад албан томилолтоор ажиллахтай холбогдох харилцааг зохицуулахаар тусган, зочид буудал, зам хоногийн зардлыг Сангийн сайдын 2011 оны 132, 188 дугаар тушаалаар баталсан тарифын дагуу олгож байхаар өөрчлөлт оруулж, Гүйцэтгэх захирлын 2016 оны А-10 дугаар тушаалаар батлуулан мөрдөн ажиллаж байна.

“Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг зөрчсөн тухай” 2014 оны 01/80 УАГ-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг бүрэн арилгажээ

2.5. Үндэсний аудитын газраас 2015 онд “Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, МУХБ-ны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар Хөгжлийн банкны бүтцийг МУХБ-ны тухай хуулинд заасан шаардлагад нийцүүлэх талаар тус банкны удирдлагад албан шаардлага өгсөн.

2.6. Албан шаардлагын дагуу МУХБ-ны ТУЗ-ийн 2015 оны 25 дугаар тогтоолоор “МУХБ-ны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай” ТУЗ-ийн 2014 оны 11 дүгээр тогтоолын хавсралтыг хүчингүй болгон шинэчлэн баталсан.

2.7. МУХБ-ны ТУЗ-ийн даргын 2016 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор МУХБ-ны бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн баталж, үүний дагуу Актив, пассив, хөрөнгийн удирдлагын газар, Төслийн санхүүжилт, зээлийн газар, Эрсдэлийн үнэлгээ, удирдлагын газар, Хяналт шалгалт, Тамгын газар гэсэн 4 газар, 13 хэлтэс, 2 алба, нийт 149 орон тоотой ажиллан, холбогдох хууль тогтоомжийн шаардлагыг хангуулсан байна.

**ТУЗ-ийн үйл ажиллагаа болон хараат бус гишүүний талаарх 2014 оны 01/82
ҮАГ-ГАГ/2014/ГА-6 дугаартай албан шаардлагад дурдсан зөрчлийг арилгасан
байна**

2.8. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Хөгжлийн банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал, түүний чөлөөт цагт Төлөөлөн удирдах зөвлөл байна” гэж заасан байна.

2.9. 2011 онд батлагдсан Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөл 9 гишүүнтэй байх ба тэдгээрийн гурав нь хараат бус гишүүн байна” гэж заасан байхад 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацаанд 8 гишүүнтэй байсан ба 2 нь хараат бус гишүүн ажилласан байна.

2.10. Мөн хуулийн 18 зүйлийн 18.2-т “Хөгжлийн банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал сард нэгээс доошгүй удаа хуралдана” гэснийг хэрэгжүүлээгүй байсан ба аудитаар өгсөн албан шаардлагын дагуу ТУЗ-ийн 2016 оны 106 дугаар тогтоолоор “МУХБ-ны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлуулан мөрдөн ажилласнаар ээлжит хурлыг сар бүр нэг удаа хийдэг болсон байна.

2.11. МУХБ-ны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.5, 19.6 дахь хэсэгт ТУЗ-ийн хараат бус гишүүдэд тавигдах шаардлагыг заасан ба банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд бус байх, банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшдэггүй байх зэрэг хязгаарлалт, шаардлагууд тавигдах болсон байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хангалттай хэрэгжүүлж ажилласны үр дүнд Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн орчин сайжирч, өмнөх аудитаар илэрсэн зөрчил, дутагдал давтан гарах шалтгаан, нөхцөл арилсан байна.
2. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан аудитын зөвлөмжид тусгагдсан зарим зохицуулалтыг цаашид мөрдөх шаардлагагүй болсон байна.

Монгол Улсын Хөгжлийн банкнаас ирүүлсэн санал:



**МОНГОЛ УЛСЫН
ХӨГЖЛИЙН БАНК**

Монгол Улс, Улаанбаатар хот 14210, Сүхбаатар дүүрэг
1 дүгээр хороо, Энхтайвны өргөн чөлөө-19
Утас: +(976) 70130513
Факс: +(976) 70130602

2017. 5. 19 № 2/727
танай -ны № -т

Тайлбар хүргүүлэх тухай

Танай байгуулагаас 2015 онд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд давтан аудит хийж олон нийтэд мэдээлэх зорилго бүхий гүйцэтгэлийн аудитын тайланд дараах тайлбарыг хүргүүлж байна.

1. Тус тайлангийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаж байна.
2. 2015-2016 онд УБХБ-нд байршуулсан харилцах, хадгаламж эрсдэлийг тооцсон хязгаарыг хэтрүүлсэн байсныг 2017 оны 1-р улирлын эцсийн байдлаар буцаан татаж эрсдэлийн зохих түвшинд бууруулсан болно. Мөн 2016 оны 10-р сар 10-ны өдрийн Актив Пассивын Удирдлагын хорооны шийдвэрээр арилжааны банкинд байршуулах мөнгөн хадгаламжийн дээд хэмжээг тухайн банкны активын 10% хүртэл хэмжээнд байхаар шийдвэрлэн мөрдөн ажиллаж байна.
3. Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн шинэчилсэн найруулга 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд уг хуулийн 19.1 дэх хэсэгт "Хөгжлийн банкны төлөөлөн удирдах зөвлөл есөн гишүүнтэй байх бөгөөд тэдгээрийн дөрөв нь хараат бус гишүүн байна." гэж, Түүнчлэн мөн хуулийн 19.5, 19.6 дахь хэсэгт Хөгжлийн банкны хараат бус гишүүдэд тавигдах шаардлагыг заасан ба тухайлбал, банкны эрх бүхий албан тушаалтан, түүний холбогдох этгээд бус байх, банкны хувьцааны тав ба түүнээс дээш хувийг дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмшдэггүй байх зэрэг хязгаарлалт, шаардлагууд тавигдсан болно.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.БАТБАЯР

Тайлбар 1-ийг
үзнэ үү.

Тайлбар 2-ыг
үзнэ үү.

Холбогдох байгууллагын саналд өгөх тайлбар:

- | | |
|-----------|---|
| Тайлбар 1 | Саналыг хүлээн авч, аудитын тайланд зохих ёсоор тусгасан болно. |
| Тайлбар 2 | Саналыг хүлээн авч, аудитын тайлангийн 2.11-т зохих ёсоор тусгасан болно. |



2017 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.39 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хөгжлийн банкны хөрөнгөөр санхүүжүүлсэн зарим арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн аудитын зөвлөмжийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Хөгжлийн банкинд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Монгол Улсын Хөгжлийн банкинд зөвлөсүгэй.

4. Аудитын тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2017 оны 4 дүгээр улиралд багтаан танилцуулахыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор (М.Давааням)-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Tushaal\2017\0606GAG1.docx.Docx

070456

ТЭМДЭГЛЭЛ

[illegible]